



**WORLD BANK GROUP**

**IFC**

International  
Finance Corporation

**MIGA**

Multilateral Investment  
Guarantee Agency

**Монгол Улс, Улаанбаатар хотод:**

Шао Ян - ОУСК

Утас: (202) 555-2121

Цахим шуудан: [yshao1@ifc.org](mailto:yshao1@ifc.org)

**АНУ, Вашингтон хотод:**

Фред Жоунс - ОУСК

Утас: (202) 473-9336

Цахим шуудан: [fjones@ifc.org](mailto:fjones@ifc.org)

Кара Сантос Пианеси – ХООТДА (MIGA)

Утас: (202) 458-2097

Цахим шуудан: [csantospianesi@worldbank.org](mailto:csantospianesi@worldbank.org)

**ОУСК, ОТХОБА Монголын ажил эрхлэлт, эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр болсон Оюу толгой компанид хоёр тэрбум гаруй ам. долларын санхүүжилт олгохоор боллоо.**

**Монгол Улс, Улаанбаатар хот, 2015 оны 12-р сарын 16-ны өдөр** – Дэлхийн Банкны Группын гишүүд болох Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлаг (ОТХОБА буюу MIGA) дэлхийн жишигт хүрсэн “Оюу толгой” зэс, алтны уурхайн бүтээн байгуулалтыг дэмжиж, 2.2 тэрбум ам. долларын зээл олгож, баталгаа гаргах гэрээг өнөөдөр үзэглэлээ. Оюу толгой нь ирэх хэдэн арван жилд Монгол Улсад ажлын байр бий болгож, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх төсөл юм.

Өмнийн Говьд байршилтай Оюу толгой нь дэлхийн хамгийн том, ашиглагдаагүй байгаа зэс, алтны ордуудын нэг бөгөөд уурхай наанадаж 40 жилийн хугацаанд ашиглагдах тооцоо байдаг. Уг ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулснаар хэдэн мянган ажлын байр бий болж, улсын төсөвт хэдэн тэрбум ам. долларын орлого төвлөрч, мөн хэмжээний хөрөнгө эдийн засагт орж ирэх ба мэргэжлийн сургалтыг өргөн цар хүрээнд явуулахад ихээхэн дэмжлэг болно.

Оюу толгой орд нь тодорхой үе шаттайгаар эдийн засгийн эргэлтэд орж байгаа бөгөөд эхний шат буюу ил уурхай нэг тэрбум гаруй ам. долларын татвар, хураамжийн орлогыг Монгол Улсын Засгийн газарт төвлөрүүлжээ. Үүн дээр нэмээд дотоодын бизнесүүд, ханган нийлүүлэгчид 2010 оноос хойш дөрвөн тэрбум ам. долларын борлуулалтыг хийж гүйцэтгэсэн байна. Дэлхийн Банкны Группээс өнөөдөр зарлаж байгаа энэхүү санхүүжилт нь тус уурхайн хоёрдугаар шат болох далд уурхайн бүтээн байгуулалтанд зориулагдах юм.

ОУСК Оюу толгой төслийн санхүүжилтэд зориулж нэг тэрбум хоёр зуун хорин нэгэн сая ам. долларын зээл олгож байгаа бөгөөд үүнд BNP Paribas, Австрали болон Шинэ Зеландын Банкны Групп, ING Банк, Société Générale, Sumitomo Mitsui Банкны Корпораци, Standard Chartered Банк, Canadian Imperial Bank of Commerce, Crédit Agricole, Intesa Sanpaolo, Австралийн Үндэсний Банк, Natixis, HSBC Банк, The Bank of Tokyo-Mitsubishi UFJ, KfW IPEX-Bank, Nederlandse Financierings-Maatschappij voor Ontwikkelingslanden зэрэг гадаадын 15 банкны хамтран санхүүжүүлж буй зээл багтаж байна. ОТХОБА -ын тухайд эдгээр банкуудын 13-т нь нэг тэрбум хүртэлх ам. долларын баталгаа гаргахаар боллоо. Оюу толгой ХХК-ийг Рио Тинто Компанийн шууд бус эзэмшлийн Туркойз Хилл Ресурс компани ба Монгол Улсын төрийн өмчит Эрдэнэс Оюу толгой компани хамтран эзэмшдэг бөгөөд энэхүү зээл нь тус компанийн зохион байгуулж байгаа 4.4 тэрбум ам. долларын зээлийн санхүүжилтийн нэг хэсэг нь юм. Мөн түүнчлэн ОУСК нь төслийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлыг ОУСК-ийн Гүйцэтгэлийн Стандартын дагуу хянахад оролцон ажиллаж байна.

Энэ үйл явдалтай холбогдуулан ОУСК-ийн Дэд Бүтэц, Байгалийн Нөөц хариуцсан захирал Сужой Боүс хэлэхдээ “Оюу толгой бол зардал багатай үйл ажиллагаагаараа түүхий эдийн мөчлөгийн туршид өрсөлдөх чадвараа алдахгүй байх, дэлхийн хамгийн том зэс, алтны уурхайн бүтээн байгуулалтын төсөл юм. Рио Тинто компани, олон улсын түнш банкуудын дэмжлэгтэйгээр уг төслийн хэрэгжүүлэлтэд ахицтай ажиллаж байгаад баяртай байна” гэж онцлон тэмдэглэв. Тэрээр “Оюу толгой компани орон нутагт ажлын байр бий болгож, Монгол Улсад бизнесийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ олон улсын шилдэг туршлагыг мөрдөн ажиллахад нь ОУСК тууштай анхаарал хандуулж ажиллах болно” гэж нэмж хэллээ.

ОТХОБА -ийн Дэд Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал Кейко Хонда “Оюу толгой төслийг далд уурхайгаар өргөжүүлэхэд гарч болзошгүй эрсдэлийг хуваахад хамтарч, чухал үүрэг гүйцэтгэж байгаадаа бид их баяртай байна” гэж тэмдэглээд “Манай баталгааны үр дүнд зээлийн санхүүжилт хамгийн оновчтой байдлаар шийдэгдэж, санхүүжүүлэгч, ивээн тэтгэгчдийн эхлүүлсэн нүсэр их ажлыг амжилтанд хүргэхэд хувь нэмэр оруулж чадлаа. Энэ санхүүжилт Монголчуудын хувьд ямар их ач холбогдолтой болохыг мөн онцлох нь зүйтэй. Хэдэн мянган ажлын байр шинээр бий болж, дэд бүтэц боловсронгуй болж, холбогдох сургалт чанарын өндөр түвшинд явагдаж, улсын төсөвт их хэмжээний орлого төвлөрөх зэргээр Монголчууд Оюу толгой төслөөс үр өгөөж хүртэж чадна” гэж хэллээ.

### **ОУСК-ийн тухай**

ОУСК нь Дэлхийн Банкны Группын гишүүн бөгөөд шинэ тутам хөгжиж байгаа зах зээлтэй орнуудын хувийн хэвшилтэй хамтран ажилладаг дэлхийн хамгийн том хөгжлийн байгууллага юм. Дэлхийн хэмжээнд хоёр мянга гаруй бизнесүүдтэй хамтран ажиллахдаа боломжийг хамгийн их хэрэгцээтэй газар нь бий болгохын төлөө өөрийн хөрөнгө, мэдлэг туршлага, нөлөөллөө дайчилж байна. 2015 оны санхүүгийн жилд хөгжиж буй орнуудад хийгдсэн манай урт хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 18 тэрбум ам. долларт дөхөж өссөн бөгөөд туйлын ядуурлыг арилгаж, хүртээмжтэй хөгжил цэцэглэлтийг дэмжихэд чиглэсэн дэлхий нийтийн хүчин чармайлтад хувийн хэвшил шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг билээ. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл [www.ifc.org](http://www.ifc.org) хуудсаар зочилно уу.

### **ОТХОБА-ийн тухай**

ОТХОБА нь Дэлхийн Банкны Группын гишүүн бөгөөд 1988 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн шинэ тутам хөгжиж байгаа эдийн засагт орж байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, ард иргэдийн аж байдлыг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна. ОТХОБА нь хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч нарт улс төрийн эрсдэлийн даатгал, зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэн, өөрийн үүргээ хэрэгжүүлж байгаа билээ. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл [www.miga.org](http://www.miga.org) хуудсаар зочилно уу.

### **Холбоотой бай**

[www.facebook.com/IFCwbq](https://www.facebook.com/IFCwbq)

[www.twitter.com/IFC\\_org](https://www.twitter.com/IFC_org)

[www.youtube.com/IFCvideocasts](https://www.youtube.com/IFCvideocasts)

[www.ifc.org/SocialMediaIndex](http://www.ifc.org/SocialMediaIndex)

[www.instagram.com/ifc\\_org](https://www.instagram.com/ifc_org)

[www.twitter.com/MIGA](https://www.twitter.com/MIGA) World Bank